



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 09 өдөр

Дугаар 2/НЗ

Чингис хот

Коронавируст халдвар (Ковид-19)-аас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлын нөөцийг бүрдүүлэхэд хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.5 "а", 29.1.1 "а", Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.12, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, 11.1.4, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Коронавируст халдвар (Ковид-19)-ын болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлын нөөцийг бүрдүүлэхэд шаардлагатай оношлуурыг худалдан авахад 42.000.000 (дөчин хоёр сая) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.1 дэх заалтын хүрээнд санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Нямдаваа)-т зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Ч.Чогсомжав)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ИДЭРБАТ



231012030

Аймгийн Засаг даргын 2021 оны
...09 дугаар сарын 09 өдрийн А/423
дугаар захирамжийн хавсралт

Коронавируст халдвар /Ковид-19/-ын болзошгүй
эрсдэлийг бууруулахад шаардлагатай зардлын тооцоо

	Бараа материалын нэр	Хэмжих нэгж	Нэгж үнэ	Шаардлагатай хамгаалах хэрэгсэл	
				Тоо хэмжээ	Мөнгөн дүн
1	Түргэвчилсэн оношлуур	ш	14000	3000	42,000,000
Нийт дүн					42,000,000